

## МОНГОЛЫН ШҮҮГЧДИЙН ХОЛБООНЫ ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монголын Шүүгчдийн Холбоо нь /цаашид Холбоо гэх/ шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлэх, шүүгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг төлөөлж, хамгаалах, мэргэшил, мэдлэг, шүүн таслах ажиллагааны ур чадвар, ёс зүйг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Олон улсын Холбоо, гадаад орны шүүгч, хуульчдын зорилго нэгтэй байгууллагатай хамтран ажиллах үндсэн зорилго бүхий гишүүддээ үйлчлэх, ашгийн төлөө бус, мэргэжлийн төрийн бус байгууллага мөн.

1.2. Холбооны оноосон нэр нь "Монголын Шүүгчдийн Холбоо", албан ёсны хаяг нь Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж, Улсын Дээд шүүхийн ордон, 7 давхар, 709 тоот, утас: 70114100

*/Холбооны Ээлжит Их хурлаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

1.3. Холбоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай болон шүүгч, шүүхийн байгууллагын эрх зүйн байдал, үйл ажиллагааг тогтоосон хуулиуд, Олон улсын шүүгчдийн холбооны "Шүүгчдийн нийтлэг тунхаглал", Шүүхийн ёс зүйн Банглорын зарчмууд, хуульд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.4. Холбоо нь өөрийн байр, билэг тэмдэгтэй байж, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

### Хоёр. Холбооны үйл ажиллагааны үндсэн зарчим

2.1. Холбооны зохион байгуулалт нь нэгдмэл байж, үйл ажиллагаа нь ардчилсан, нээлттэй, ил тод, төрийн байгууллагаас хараат бус, мэргэжлийн, сайн дурын, өөрөө өөрийгөө удирдах зарчимд тулгуурлана.

2.2. Холбоо нь ижил зорилго бүхий олон улсын байгууллагад гишүүнээр элсэх, гадаад, дотоодын байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг эрмэлзэнэ.

2.3. Холбоо нь шүүн таслах болон бусад төрийн чиг үүргийг орлон гүйцэтгэхгүй, ямар нэгэн байдлаар оролцохгүй, ашиг олох болон улс төрийн үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд гишүүдийг нас, хүйс, шашин шүтлэг, үзэл бодол, албан тушаалаар нь ялгаварлахгүй.

### Гурав. Холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэл

3.1. Холбоо нь энэхүү дүрмийн 1.1-д заасан зорилгодоо хүрэхийн тулд 2.1-д заасан зарчмыг удирдлага болгон дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

Үүнд:

3.1.1. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүх эрх мэдлийн тогтолцоог боловсронгуй болгох, шүүгч, шүүхийн байгууллагын эрх зүйн байдал, үйл ажиллагааг тогтоосон хуулиудад заасан шүүгчийн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгааг хангуулахад шаардлагатай асуудлаар гишүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг нэгтгэн хууль санаачлагч болон хууль тогтоох байгууллагад хүргүүлэх;

3.1.2. Шүүгчдийн мэдлэг, боловсрол, шүүн таслах ажиллагааны ур чадварыг дээшлүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сахих чадварыг хэвшүүлэх, гишүүд мэдлэг, туршлагаа солилцоход дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах, гарын авлага, ном сэтгүүл хэвлэн гаргах;

3.1.3. Шүүхийн бие даасан, шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудлаар эрдэм шинжилгээний бага хурал, сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, хэвлэл мэдээллийн хурал зохион байгуулах

3.1.4. Гадаад, дотоодын ижил зорилго бүхий байгууллагатай харилцаа тогтоох, хамтран ажиллах, шүүгчдийн сургалт, айлчлалыг харилцан зохион байгуулах, түүнчлэн шүүгчид дээрх байдлаар харилцаа тогтоох, харилцан мэдээлэл туршлага солилцох, хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх;

3.1.5. Гишүүдийнхээ үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр таниулах, энэ чиглэлээр хэвлэл, мэдээллийн байгууллагатай харилцаа тогтоох, хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх;

3.1.6. Шүүгчдийг боловсрол, мэдлэгээ дээшлүүлэх бололцоогоор хангагдахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх, шаардлагатай бол тэднийг холбогдох байгууллагад тодорхойлох, төлөөлөх;

3.1.7. Шүүгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах, шаардлагатай бол гишүүдийн талаарх мэдээллийг цаг тухайд нь судалж, тухайн гишүүний хүсэлтийг үндэслэн хариу мэдээлэх;

3.1.8. Гишүүддээ сэтгэл санааны болон эд материалын туслалцаа үзүүлэх;

3.1.9. Хууль, дүрэмд заасан бөгөөд Төрийн бус байгууллагад хүлээн зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагааны хэлбэр;

## **Дөрөв. Холбооны Их Хурал**

4.1. Холбооны эрх барих дээд байгууллага нь Холбооны Их хурал мөн.

4.2. Их хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит Их хурлыг 4 /дөрөв/ жил тутамд хуралдуулна. Холбооны тэргүүн Их хурлыг даргалах ба хуралдааны нарийн бичгийн дарга болон дэгийг Их хурлаар батламжлуулна.

*/Холбооны Ээлжит Их хурлаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

4.3. Ээлжит болон ээлжит бус Их хурлыг Холбооны удирдах зөвлөлийн шийдвэрээр зарлан хуралдуулна. Их хурлыг цахим (цахим санал хураалт) хэлбэрээр зохион байгуулж болно.

4.4. Холбооны Их Хурал нийт гишүүдийн олонх оролцсоноор хүчинтэйд тооцогдох бөгөөд бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.

*/Холбооны Ээлжит Их хурлаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

4.5. Холбооны Их Хурал /ээлжит болон ээлжит бус/ дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.5.1. Холбооны дүрмийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах

*/Холбооны Ээлжит бус Их хурлаар 2023 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

4.5.2. Холбооны удирдах зөвлөлийн ажлын тайланг хэлэлцэх, мэдээлэл сонсох;

4.5.3. Холбооны хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэх, мэдээлэл сонсох;

4.5.4. Холбооны удирдах болон хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох;

4.5.5. Шүүгчдийн холбооны тэргүүнийг сонгох

4.5.6. Холбоог өөрчлөн байгуулах, бүтэц зохион байгуулалтыг тогтоох, татан буулгах;

4.5.7. Холбооны гишүүдийн татварын хэмжээг тогтоох;

4.5.8. Удирдах зөвлөлөөс Их хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх шаардлагатай гэж үзсэн бусад агуулга;

*/Холбооны Ээлжит Их хурлаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

4.6. Хуралд оролцох гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар Их Хуралд хүрэлцэн ирэх боломжгүй бол саналаа битүүмжлэн бичгээр ирүүлж болно. Тухайн ирүүлсэн саналыг хэлэлцэх журмыг хуралдааны дэгээр зохицуулна.

4.7. Тэргүүн, Удирдах зөвлөлийн болон хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн хэн нь ч олонхын санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт гишүүдийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулж, олонхын санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно. Холбооны гишүүн Тэргүүн болон удирдах зөвлөлийн гишүүнд нэгэн зэрэг нэр дэвшихгүй бөгөөд аль нэгийг сонгож нэрээ дэвшүүлнэ.

*/Холбооны Ээлжит Их хурлаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

4.8. Холбооны Их хурлын тогтоолд тухайн хурлын дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

4.9. Сонгуулийг нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох зарчмын үндсэн дээр явуулах бөгөөд нэр дэвших, сонгуулийг зохион байгуулж, явуулахтай холбогдсон журмыг удирдах зөвлөл батална.

*/Холбооны Ээлжит Их хурлаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

## **Тав. Холбооны удирдах зөвлөл**

5.1. Холбооны Их хурлын чөлөөт цагт Холбооны удирдлагыг Удирдах зөвлөл гүйцэтгэнэ.

5.2. Удирдах зөвлөл холбооны тэргүүн 1, орон тооны бус 8, нийт 9 гишүүнээс бүрдэх бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхийн 1, давж заалдах шатны шүүхийн 3, анхан шатны шүүхийн 5 гишүүний төлөөлөл байна.

5.3. Тэргүүн болон удирдах зөвлөлийн гишүүдийг 2 жилийн хугацаагаар сонгох ба улираан сонгож болно.

*/Холбооны Ээлжит Их хурлаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

5.4. Удирдах зөвлөлийн хуралдааныг Тэргүүн даргалж явуулах бөгөөд хуралдаан ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна.

5.5 Удирдах зөвлөлийн ээлжит хуралдааныг жилд улирал бүрийн эхний сарын 15-ны өдрийн дотор, ээлжит бус хуралдааныг зөвлөлийн гишүүдийн 50-иас дээш хувийн санал болон тэргүүний санаачилгаар хуралдуулна.

5.6. Удирдах зөвлөлийн хуралд гишүүдийн 50 хувиас доошгүй нь оролцсоноор хүчинтэйд тооцогдох бөгөөд бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралдаанд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол, тэмдэглэл гаргана.

*/Холбооны Ээлжит Их хурлаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр хасалт оруулсан/*

5.7. Удирдах зөвлөлийн хуралдааны тогтоолд Холбооны тэргүүн эсхүл тэргүүнийг орлож буй гишүүн гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

*/Холбооны Ээлжит бус Их хурлаар 2023 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

5.8. Дараах тохиолдолд удирдах зөвлөлийн гишүүний нөхөн сонгуулийг явуулна.

5.8.1. Чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

5.8.2. Өөр шатны шүүхэд болон бусад албан тушаалд томилогдсон, сонгогдсон зэрэг шалтгаанаар энэ дүрмийн 5.2-д заасан шүүхийг төлөөлөх боломжгүй болсон;

5.8.3. Холбооны гишүүнчлэлээс татгалзсан эсхүл гишүүнчлэл нь дуусгавар болсо;

*/Холбооны Ээлжит Их хурлаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

5.9. Удирдах зөвлөл дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.9.1. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх, татан буулгах саналыг Холбооны Их хуралд оруулах;

5.9.2. Холбооны жил бүрийн ажлын төлөвлөгөө, төсвийг баталж, биелэлтэд нь хяналт тавих;

5.9.3. Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах зөвшөөрлийг Тэргүүнд өгч, Холбооны хөрөнгийг захиран зарцуулахтай холбогдуулан гүйцэтгэх захирлын эдлэх эрх, үүргийг тогтоох;

5.9.4. Холбооны Их хурлыг зарлан хуралдуулах

5.9.5. Холбооны Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх, тайланг хэлэлцэх;

5.9.6. Салбар хороодыг болон гишүүнийг шагнах, урамшуулах асуудлыг шийдвэрлэх, Холбооны нэрэмжит шагналыг бий болгох, олгох журмыг батлах;

5.9.7. Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, түүний төсвийг батлах;

5.9.8. Тодорхой үйл ажиллагааны төрөл, чиглэлээр хороо байгуулах, өөрчлөх, татан буулгах, тэдгээрийн удирдлагыг гишүүдийнх нь саналыг харгалзан томилж, чөлөөлөх

*//Холбооны Ээлжит бус Их хурлаар 2023 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

5.9.9. Гишүүний татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх журам батлах, энэ талаар гишүүдээс гаргасан хүсэлтийг хэлэлцэж шийдвэрлэх

*//Холбооны Ээлжит бус Их хурлаар 2023 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

5.9.10. Хууль, энэ дүрэмд нийцсэн, Холбооны их хурал, тэргүүн, гүйцэтгэх захирал, хяналтын зөвлөл, салбар хороодын эрх хэмжээнд хамааруулаагүй бусад эрх

5.10. Удирдах зөвлөл ажиллах журам, хурлын дэг, бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой бусад журмыг баталж, биелэлтэд хяналт тавина.

*/Холбооны Ээлжит бус Их хурлаар 2023 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

*/Холбооны Ээлжит Их хурлаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

## **Зургаа. Холбооны тэргүүн**

6.1. Холбооны тэргүүн нь орон тооны бус байна.

6.2. Холбооны тэргүүн дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.2.1. Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх, Удирдах зөвлөлөөс сонгосон гүйцэтгэх захиралтай хөлсөөр ажиллах гэрээг тодорхой хугацаагаар байгуулж, биелэлтэд хяналт тавих

6.2.2. Удирдах зөвлөлийн хуралдааныг зарлан хуралдуулж, хуралдааныг даргалах;

6.2.3. Удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөөг батлах, биелэлтэд хяналт тавих;

6.2.4. Дүрэмд заасан бусад бүрэн эрх;

6.3. Холбооны тэргүүн бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргана. Тэргүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй буюу өвчтэй, чөлөөтэй зэрэг хүндэтгэн үзэх шалтгаан үүссэн тохиолдолд хяналтын шатны шүүхээс сонгогдсон Удирдах зөвлөлийн гишүүн, хэрэв тус гишүүн хүндэтгэх шалтгаантай бол Удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос олонхын санал авсан гишүүн тэргүүний бүрэн эрхийг түр орлон хэрэгжүүлж, үүнээс үүдэн гарах хариуцлагыг хүлээнэ.

*/Холбооны Ээлжит бус Их хурлаар 2023 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

6.4. Холбооны санхүүгийн ажил хариуцсан ажилтан /нягтлан бодогч/, нарийн бичгийн дарга, хэвлэл мэдээлэл хариуцсан зэрэг ажилтнуудыг Холбооны тэргүүний захирамжаар зохих мэргэжлийн хүнийг гэрээгээр ажиллуулахаар шийдвэрлэж болно.

## **Долоо. Холбооны хяналтын зөвлөл**

7.1. Хяналтын зөвлөл нь Холбооны болон салбар хорооны үйл ажиллагаа, хөрөнгө, санхүүгийн зарцуулалтад хяналт тавина.

7.2. Холбооны тэргүүн, Удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал түүнчлэн хөдөлмөрийн гэрээт ажилтанг Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгохгүй.

7.3. Хяналтын зөвлөл жилд хоёроос доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд хэдийд ч хуралдаж болно.

7.4. Хяналтын зөвлөл үйл ажиллагаатайгаа холбогдсон аливаа мэдээ, бичиг баримтыг холбооны Тэргүүн, Гүйцэтгэх захирал, Салбар хорооны тэргүүн зэрэг холбогдох этгээдүүдээс саадгүй гаргуулан авах, холбогдох мэргэжлийн хүнийг хяналтын үйл ажиллагаанд татан оролцуулах эрхтэй.

7.5. Хяналтын зөвлөл нь 3 гишүүнтэй байна. Хяналтын зөвлөлийн гишүүнийг Холбооны Их хурлаас дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

*/Холбооны Ээлжит Их хурлаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

7.6. Хяналтын зөвлөл илэрсэн дутагдлыг тухай бүр Их хурал болон Удирдах зөвлөлд мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авахуулна.

## **Найм. Холбооны салбар хороо**

8.1. Холбоо нь дараах салбар хороодтой байна.

8.1.1. Улсын дээд шүүхийн салбар хороо;

8.1.2. Шүүн таслан ажиллагааны дагнасан төрөл, байршил, нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу байгуулагдсан Нийслэл дэх шүүх бүр салбар хороотой байна. Нэг аймаг дахь бүх шатны шүүхүүд нь нэгдмэл нэг салбар хороотой байх ба аймгийн төвөөс өөр газар байршилтай шүүхүүдийн хувьд тусдаа салбар хорооны зохион байгуулалттай байж болно;

*/Холбооны Ээлжит Их хурлаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

8.2. Салбар хорооны тэргүүнийг тухайн салбар хорооны гишүүдийн олонхын саналаар гурван жилийн хугацаагаар сонгоно. Хэрэв салбар хорооны тэргүүнийг сонгоогүй бол тухайн салбар хорооны шүүгчдээс хамгийн олон жил ажилласан шүүгч нь тэргүүний үүргийг гүйцэтгэнэ. Салбар хороо нь Холбооны дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах хэлбэрээ өөрөө тогтооно.

*/Холбооны Ээлжит бус Их хурлаар 2023 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

8.3. Салбар хороо бүр гишүүдээсээ Холбооны тэргүүн, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд нэр дэвшүүлэх эрхтэй. Салбар хорооноос нэр дэвшээгүй нь энэ дүрмийн 10.3.7-д заасан эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

8.4. Салбар хороо, түүний Тэргүүн нь Холбоо, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулж, Холбооны нэгдмэл удирдлага зөвлөгөөг авч, тайлагнаж ажиллана.

## **Ес. Холбооны Гүйцэтгэх захирал, ажлын алба**

9.1. Гүйцэтгэх захирал нь холбоог дотоод, гадаадад төлөөлөх бөгөөд холбооны гишүүн бус этгээд томилогдож болно.

9.2. Холбооны Гүйцэтгэх захирал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.2.1. Холбооны ажлын төлөвлөгөөг боловсруулах, биелэлтийг зохион байгуулж, хангах;

9.2.2. Удирдах зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг зохион байгуулах;

9.2.3. Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлж, ажлын албыг удирдана,

9.2.4. Холбооны мөнгөн хөрөнгийг удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд, гэрээнд заасан зориулалтаар захиран зарцуулах

9.2.5. Холбооны гишүүдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, холбогдох бусад баримт материалыг бүрдүүлэх, хадгалах, гишүүний бүртгэлд шаардлагатай хөдөлгөөн хийх,

9.2.6. Холбооны албан ёсны цахим хуудсыг зохих хэмжээнд байнгын ажиллагаатай байлгаж, холбогдох мэдээллийг цаг алдалгүй байрлуулах

9.2.7. Холбооны албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдгийг хариуцаж ажиллах,

9.2.8. Салбар хороодын Тэргүүнтэй шууд харилцах, зохион байгуулалтын удирдлагаар хангах;

9.2.9. Дүрэм болон гэрээнд заасан бусад бүрэн эрх;

9.3. Гүйцэтгэх захирал нь өөрийн бүрэн эрхийн хугацаа дууссан нөхцөлд шинээр гүйцэтгэх захирлыг сонгох хүртэл албан үүргээ хэвээр гүйцэтгэнэ.

9.4. Холбоо нь ажлын албатай байх бөгөөд нягтлан бодогч, нарийн бичгийн дарга, туслах ажилтан, хэвлэл мэдээллийн эх бэлтгэгч дизайнер буюу медиа менежер зэрэг орон тооны ажилтнуудтай байж болно. Ажлын албаны бүтцийг Удирдах зөвлөл тогтооно.

## **Арав. Холбооны гишүүнчлэл**

10.1. Монгол Улсын шүүхийн шүүгч нь Монголын шүүгчдийн холбооны гишүүн (цаашид гишүүн гэх) байна. Шүүгч нь Холбоонд эвлэлдэн нэгдэх эрхээ сайн дураар илэрхийлж, Холбооны гишүүдийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэнээр гишүүний эрх, үүрэг үүснэ. Шүүгчдийн нэгдсэн бүртгэлтэй холбоотой харилцааг Холбооны гишүүний бүртгэлийн нэгдсэн журмаар зохицуулна.

*/Холбооны Ээлжит бус Их хурлаар 2023 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

10.2. Өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад шүүгч өөрөө хүсвэл Холбооны гишүүнээр хэвээр үлдэх эрхтэй.

10.3. Холбооны гишүүн нь дараах эрхийг эдэлнэ:

10.3.1. Холбооны удирдах байгууллагад сонгох, сонгогдох;

10.3.2. Холбооны удирдах байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, шүүгчдийн өмнө тулгамдсан асуудлыг хэлэлцэхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;

10.3.3. Хууль тогтоомж болон энэхүү дүрэмд заасны дагуу эрхээ хамгаалуулах, дэмжлэг тусалцаа хүсэх;

10.3.4. Үндэслэл, шалтгаанаа бичгээр илэрхийлсэн хүсэлтээр холбооны гишүүнчлэлээс татгалзах

*/Холбооны Ээлжит бус Их хурлаар 2023 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

10.3.5. Холбооны тайлантай танилцах;

10.3.6. Холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зорилгод нийцсэн тодорхой ажиллагааг зохион байгуулах зорилгоор клубын хэлбэрээр нэгдэж ажиллах;

10.3.7. Холбооны Тэргүүн, Удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлэх, бусад гишүүний нэрийг дэвшүүлэх;

10.3.8 Ахмад шүүгч гишүүн нь Холбооны гишүүний татвараас 50 хувь чөлөөлөгдөх;

10.3.9. Холбооны дүрэм, үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах асуудлаар Удирдах зөвлөлд санал гаргах;

*/Холбооны Ээлжит Их хурлаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

10.4. Холбооны гишүүн дараах үүрэгтэй:

10.4.1. Төрийн бус байгууллагын тухай хууль, энэ дүрмийн шаардлагыг сахин биелүүлэх;

10.4.2. Холбооны Их хурлаас тогтоосон хэмжээгээр сар бүр татвар төлөх;

10.4.3. Холбооны удирдах байгууллагаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

10.5. Шүүгчийн бүрэн эрх түдгэлзсэн нь гишүүнчлэлээс болон гишүүний татвараас чөлөөлөх үндэслэл болохгүй.

10.6. Шүүгчийн албан тушаалаас огцорсон бол Холбооны гишүүнчлэл дуусгавар болно.

*/Холбооны Ээлжит бус Их хурлаар 2023 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

10.7. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 6 сар ба түүнээс дээш хугацаанд гишүүний татвараа төлөөгүй, эсхүл энэ дүрмийг хоёроос дээш, эсхүл ноцтой зөрчсөн тохиолдолд Удирдах зөвлөл тухайн гишүүнд сануулж, нийт гишүүдэд танилцуулна. Хэрэв гишүүний татварыг 1 жилээс дээш хугацаагаар төлөөгүй бол татварын өрийг төлж дуустал тухайн гишүүн Холбооны удирдах байгууллагад сонгогдох, аливаа асуудлаар санал өгөх эрхээ алдана.

*/Холбооны Ээлжит бус Их хурлаар 2023 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

*/Холбооны Ээлжит Их хурлаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

10.8. Холбооны гишүүн бус этгээдээс тус холбоонд хандаж шаардлага, хүсэлт гаргах болон холбооны үйл ажиллагаанд оролцох эрхгүй.

## **Арван нэг. Холбооны санхүүжилт**

11.1. Холбоо нь өөрийн мөнгөн болон бусад эд хөрөнгөтэй байна.

11.2. Холбооны эд хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

11.2.1. Гишүүдийн татвар, хандив;

11.2.2. Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдуулан олсон орлого;

11.2.3. Хадгаламжийн хүү, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагаас олгосон хөрөнгө;

11.3. Холбооны удирдах зөвлөл, салбар хороо, гүйцэтгэх захирал нь холбооны мөнгөн болон эд хөрөнгийг зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах бөгөөд Холбооны 1 дүгээр гарын үсгийг Гүйцэтгэх захирал, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч зурна.

11.4. Холбооны тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүн, салбар хороо, гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нарт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

11.4.1. Холбооны орлогоос ашиг хуваарилах, иргэн аж ахуйн нэгж байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах;

11.4.2. Холбооны тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирал, бусад ажилтан холбооны хөрөнгийг хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн буюу аж ахуйн үйл ажиллагаанд зарцуулах;

11.4.3. Сонгуулийн үйл ажиллагаанд буюу нам, эвсэл, нэр дэвшигчдэд хандив өргөх зэрэг болно.

11.5. Холбоо нь санхүүгийн үйл ажиллагаандаа жилийн тайлан тэнцлийг гаргаж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор харъяалах Татварын албанд, үйл ажиллагааныхаа тайланг Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт гарган өгнө.

## **Арван хоёр. Бусад**

12.1. Холбоог Их хурлын шийдвэрээр болон хуульд заасан үндэслэл, журмын дагуу татан буулгаж болно.

12.2. Энэ тохиолдолд Холбооны хөрөнгийг дүрэмд заасан зорилгод бүрэн зарцуулж дуусгалтын тайлан гаргана.

12.3. Холбоо нь өөрийн гишүүн болон холбооны удирдах байгууллагын сонгуультны хууль бус үйл ажиллагаатай холбогдсон эд хөрөнгийн болон бусад хариуцлагыг хүлээхгүй.

12.4. Холбоо нь гишүүдтэйгээ харилцах, тэднийг мэдээллээр хангах, гадаад болон олон улсын ижил төрлийн байгууллагуудтай мэдээлэл солилцох /гадаад хэл дээр танилцуулга, холбоо тогтоох хаяг бүхий/, Холбооны Их хурлыг зохион байгуулах үед санал хураалтыг цахим хэлбэрээр явуулах /вэбэд суурилсан интерактив програм/ боломж бүхий цахим хуудастай байна.

12.5. Энэ дүрэм батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Хуульд заасан журмын дагуу Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх асуудлыг Гүйцэтгэх захирал хариуцна.